

Улаанбаатар хот дахь Хүний Эрх Хөгжил төвийн харьяа Дорнод Баяндун сумын МХБХолбооны 2017 оны 11.19 аас 2022 он хүртэлх үйл ажиллагааны ажлын тайлан.

Хүний эрх хөгжил төвийн харьяа Дорнод аймгийн Баяндун сумын Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбооны танилцуулга

2017 оны 11 сарын 19-ны өдөр буюу өвлийн тэргүүн сарын шинийн нэгэнд Их эзэн богд Чингис хааны мэндэлсэн өдөр Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбоо (МХБХ) байгуулагдаж МХБХ-ны даргаар Я.Мөнхзул, ХОХСангийн зохицуулагч Л.Доржмаа, нягтлан, нярав Б. Алимаа, хяналтын зөвлөл А.Баярцогт, орон байрны зөвлөлийн даргаар Ц. Сэндэр, сургалт мэдээллийн зөвлөл Д. Нацагдорж, эрүүл мэндийн зөвлөлийн даргаар Д. Нарантуяа нар сонгогдлоо. МХБХ нь 5 бүлэг 62 гишүүнтэй. Өндөр настан 25, өрх толгойлсон эмэгтэй 12, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 5, хөдөлмөрийн насны 22 иргэн байдаг. Гишүүд нь өөрсдийн хүсэл зорилгоор нэгдэн, “Хэнийг ч орхихгүй хамтдаа хөгжье” уриатай, хөдөлмөрөө хоршин бүлэг болон ажиллаж байна.



МХБХ-оос санаачлан Дэлхийн эрүүл мэндийн өдрөөр "Ахмадын эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах эрх" сэдэвт уулзалтыг МХБХ, ЭМТөв, АШУЗХороо хамтран амжилттай зохион байгууллаа. Мөн ЭМТөвдөө МХБ-үүд улавч, онцгой гишүүд Я.Мөнхзул, Л.Доржмаа, Д.Пагма, Д.Жиндэгмаа, Б.Цэцэг нар 20ш цагаан углааш бэлэглэв.





Дэлхийн эрүүл мэндийн өдрийг угтаж Баяндун сумын УБ хот дахь Хүний эрх хөгжил төвийн харьяа МХБХ нь Баяндун сумын ЗДТГ, ЭМТөв, Ахмадын хороо, Улаан загалмайн анхан шатны хороо, Хүний эрх хөгжил төвтэй (ХЭХТ) хамтран “Ахмадын эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах” сэдэвт уулзалт 4

сарын 6-нд соёлын төвд зохион байгууллаа. Тус үйл ажиллагааны нээлтийг МХБХ-ны удирдах зөвлөл ЗДТГ-ын орлогч дарга Б.Бат-эрдэнэ, МХБХ-ны дарга Я. Мөнхзул, ХОХСангийн дарга Л. Доржмаа нар нээж мөн холбооны бүтэц зохион байгуулалт, хийсэн ажлын тайланг илтгэв. ХЭХТ, Help age интернешнл байгуулагын танилцуулга сумын нийгмийн ажилтан Г. Чулуунцэцэг, Ахмад настнуудын эрүүл мэндийн асуудлын талаар ЭМТ-ийн дарга Б. Сэргэлэнбаатар Ахмадын эрх сэдвээр ахмад настан Ц. Долгормаа, Ахмад настны хуулийн тухай “Угтам” бүлгийн гишүүн Г. Наранжаргал нар илтгэл тавьж мэдээлэл хийлээ. Сумын МХБ-үүд ахмадууд амьдралд тулгамдаж буй асуудлаар тоглолт, урлагийн номер үзүүлж хийсэн ажлаа тайлагнаж, ярилцлага зохион байгуулахаас гадна цэнгүүн зохион байгуулав.

“Тогтвортой хөгжлийн зорилтууд ба бидний оролцоо”
Дорнод Баяндун сум
2018.05.24-25





Баяндун сумын МХБХ нь “Better World” Олон улсын байгууллагын Баяндун сум дахь бие төлөөлөгч М.Мөнхзоригтой хамтарч ажиллахаар болов. Ийнхүү хамтын ажиллагааны хүрээнд сумын “Ногоочид” -ын холбоотой хамтарч гүний худаг гаргуулах хүсэлт явуулснаар нь “Better World” Олон улсын байгууллага иргэдийн хүсэлтийг хүлээн авч 5000000 төгрөгний төсөл хэрэгжүүлж үнэ төлбөргүй гүний худаг гаргаж өгөв.

“Better World” Олон Улсын
Байгууллагын захирсанад

Улаанбаатар хотын Хүний Эрх,
Хөгжил Төвийн харьяа Баяндун
сумын Мөнгөн Хуримтлалын
Бүлгүүдийн холбооны хүсэлт

Наранбулаг 2018.5.22

Баяндун сумын Наран багийн харьяа МХБХолбоо 5 бүлэг 62
гшүүнгтэй. Үүнээс өндөр настай 27, өрх толгойлсон эмэгтэй 12, хөгжлийн
бэрхшээлтэй иргэн 5, хөдөлмөрийн насны 24 иргэн байна. Бид хэний ч
өрхнгүй хамтдаа хөгжж уриатай, бүлэг болон хамтарч ажилласнаар
өрхийн амьдралаа дээшлүүлэх зорилготой. Бид бүлгээрээ эрүүд чанартай
төрөл бүрийн хүнсний ногоо тариалан өрх гэрйвхээ хэрэгцээг хангасаас
гадаа бусдад худалдаалан хуримтлалаа өсгөнө. МХБХ нь ногоо тариалж
газартай болсон боловч усны 38 үүсвэр болох Наранбулагийн усны
ундрага муудсан тул усны байнгын эх үүсвэртэй байгаах тал дээр дэмжлэг
үзүүлж гүний худагтай болгох асуудлыг дэмжиж шийдвэрлэж өгөхийг
хүсье!

Хүсэлт гаргасан: Баяндун сумын МХБХ



2018 оны 6 сарын 6-нд гишүүд хамтдаа төмс тарив.



2018 оны 7-р сарын 23-с 8-р сарын 3-ны хооронд ХЭХТ-ийн харьяа МХБүлгүүдийн 12 дахь Туршлага солилцох уулзалтыг Дархан уул аймгийн МХБХ амжилттай зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд Баяндун сумын бүлгийн гишүүд оролцож, мөн хийсэн ажлаа тайлагнав .



Баяндун сумын МХБХ бичиг баримтаа стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэлээ. ХЭХТ-ийн 20 жилийн ойг угтан зохион байгуулсан уралдаанд тэргүүн байр эзэлж 500.000 төгрөгөөр шагнуулав.



Баяндун сумын Дун хөгжил МХБүлэг 14 тн нүүрс худалдан авч , хагалж шуудайлан зарж хамт олны хуримтлалын сангаа өсгөж байна. **2018.12.02**





Баяндун МХБүлгүүд төмсөө хураалаа. Ургац арвин ургаж хураахад урамтай байв



ХЭХТ-ийн 20 жилийн ойд Дорнод аймаг Баяндун сумын МХБХ-оос 28 гишүүд оролцов.

Олон улсын Хүний эрхийн өдрөөр 12 сарын 10 Орон нутгаас холбоодууд ирж оролцов





Баяндун сумын МХБХолбооны 2018ны үйл ажиллагааны тайланг сумын засаг дарга Х.Хүрэлчулуунд тайлагнаж, цаашдын ажлын төлөвлөгөөгөө танилцуулав.Засаг дарга Х.Хүрэлчулуун цаашид сайн ажиллахыг хүсээд, засварлаж аваарай гээд эсгий гэр өглөө

2019.05.19 Better World ОУ-ын байгууллагаас “Ургац ногоо” төслийн 15,010,000 төгрөгөөс 491,0000 төгрөгний хашааны төслийн мөнгө орж ирснээр ногооны талбайгаа цэвэрлэж, чулууг нь түүн ногоо тарихад таатай нөхцөл бүрдүүлэх зорилгоор бордоо буулган хашаагаа барьж эхлэв.





Хүнс хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр худалдаа үйлчилгээний дарга Ч.Самбуубаатар МХБХ-ны үйл ажиллагаатай танилцаж ногоо тарихад тусламж, дэмжлэг болгон 2кг улаан манжин, 2кг лууван, 50кг гала сортын төмсний үр, 500 гр сонгины үрний дэмжлэг үзүүлэв. Бүлгүүдэд ногооны үрээ хувааж өгөв.



2019.06.01 газраа хагалуулж, ногоогоо тарьж, ногоочдын бүлгийн холбооны тэргүүн, улсын аварга ногоочин Г.Баттөмрийн хүлэмжийг нь барилцав.





2019.06.28 “Ургац ногоо” төсөл хэрэгжиж 2 дахь гүний худаг гарж хүлээн авлаа.



2019.02.20 нд Better World ОУ-ын байгууллагад МХБХ ногоочдын бүлэгтэй хамтран 1 гүний худагны төслийг хүргүүлэснээр 2019.07.25 нд орон нутгийн удирдлагууд хүлээлгэн өглөө.



ХЭХТ харьяа МХБ-ийн туршлага солилцох 13 дахь уулзалтыг Хэнтий аймгийн МХБүлгүүд амжилттай зохион байгууллаа. Үүнд Баяндун сумын МХБүлгүүд оролцож, бүтэн жилийн хийсэн ажлын тайлангаа танилцуулж, аялаж, зугаалан туршлага солилцоод ирлээ.





9.25 нд Бүлгүүд ургацаа хураав. Ургац арвин ургаж 4 бүлэг тус бүр 300 кг төмсний үртэй болж, хуримтлалын дансандаа 400000-600000 төгрөг хуримтлуулж, эрүүл хүнсний ногоо, төмсөөр өөрсдийн өвлийн бэлтгэлээ хангалаа.



“Угтам”, “Толь мандал” 2 бүлгүүдийн гишүүд бүгд өндөр настан 10.1 нд ахмадын баяраар бусад бүлгүүд нийлэн ахмадууддаа сюрприз барин 2 бүлгийн төмсөө хурааж өгөх санхүүгийн тал хувийг нь дааж төмс хураах ангуудыг олж өгсөн.



Бүлгийн гишүүд 10 тн төмс, хүнсний ногоо хурааж, ногоо даршилж өвлийн бэлтгэлээ хангалаа





Намрын налгар өдрүүд 2021 үзэсгэлэн худалдаанд бүлгийн гишүүд оролцов

